



ӨМНӨГОВЬ АЙМАГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/38

Даланзадгад

Аймгийн ерөнхий мэргэжилтний зөвлөл  
байгуулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/01 дугаар тушаалыг тус тус үндэслэн, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2020 оны 93 дугаартай албан бичгээр ирүүлсэн саналыг харгалзан ТУШААХ нь:

1. Бүс орон нутгийн хэмжээнд Эрүүл мэндийн салбарын бодлого, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Орон нутгийн удирдах дээд байгууллага, аймгийн Эрүүл мэндийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн чиглэлээр зөвлөх чиг үүрэг бүхий “Эрүүл мэндийн газрын ерөнхий мэргэжилтний орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг нэгдүгээр, “Ерөнхий мэргэжилтний орон тооны бус зөвлөлийн ажиллах журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн ерөнхий мэргэжилтний орон тооны бус зөвлөлийг дэмжлэгт удирдлага, зохион байгуулалтаар ханган, үйл ажиллагаанд явцын хяналт тавьж, хагас, бүтэн жилээр үнэлгээ өгч, үр дүнг тооцож ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс /Ж.Отгонбайгал/-д даалгасугай.

3. Ерөнхий мэргэжилтнүүдийн цалингийн урамшууллыг шаардлагатай тохиолдолд Эрүүл мэндийн газрын удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн олгож байхыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал /Я.Болдбаатар/ болон бусад холбогдох байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2017 оны А/44 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Ц.ӨНӨРЖАРГАЛ

C:\Desktop\2020 on TUSHAAL

461200114

Эрүүл мэндийн газрын даргын  
2020 оны 04 дүгээр сарын 23-ний өдрийн  
А/38 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ЕРӨНХИЙ МЭРГЭЖИЛТНИЙ ОРОН ТООНЫ  
БУС ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ГИШҮҮД /ЕРӨНХИЙ МЭРГЭЖИЛТНҮҮД/ -ИЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ

№	Нэрс	Мэргэжил	Албан тушаал	Зэрэг	Харъяалах мэргэжлүүд
1	Ж.Отгонбайгал	Эрүүл мэндийн газрын ерөнхий мэргэжилтний зөвлөлийн дарга	Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн дарга, Эх барих, эмэгтэйчүүдийн эмч	ЭМУ-ын магистр	Ерөнхий мэргэжилтнүүдийг удирдах, ажлын тайланг нэгтгэн дүгнэх, хянах, арга зүйгээр хангах
2	Ш.Нэргүймаа	Эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлэл, яаралтай тусламжийн ерөнхий мэргэжилтэн	БОЭТ-ийн эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлгийн эмч	Клиникийн профессор, АУ-ны магистр	Сэхээн амьдруулах яаралтай тусламж, Амь тэнссэн үеийн тусламж, Мэдээгүйжүүлэг
3	Б.Мөнхбат	Эх барих, эмэгтэйчүүдийн ерөнхий мэргэжилтэн	БОЭТ-ийн эх барих, эмэгтэйчүүдийн зөвлөх эмч	Ахлах зэргийн эмч, Магистрантур	НҮЭМ-ийн тусламж, үйлчилгээ, Төрөх яаралтай тусламж, Эмэгтэйчүүдийн эмгэг судлал, эмэгтэйчүүдийн хавдар судлал /хөх, умайн хүзүү/, Цус судлал
4	Т.Оюундүү	Хүүхдийн ерөнхий мэргэжилтэн	БОЭТ-ийн хүүхдийн зөвлөх эмч	Тэргүүлэх зэргийн эмч, АУ-ны магистр	Хүүхдийн өвчин судлал, нярайн эмгэг судлал, хүүхэд, нярайн сэхээн амьдруулах яаралтай тусламж, үйлчилгээ
5	Ж.Зоригт	Мэс засал, Гэмтлийн ерөнхий мэргэжилтэн	БОЭТ-ийн мэс заслын зөвлөх эмч	Ахлах зэргийн эмч	Ерөнхий мэс засал, Гэмтэл согог засал, Нүд, Нүүр ам судлал, Чих хамар хоолой



6	Т.Өлзийсайхан	Мэдрэл, сэтгэц судлалын ерөнхий мэргэжилтэн	БОЭТ-ийн мэдрэлийн зөвлөх эмч	Клиникийн профессор, Ахлах зэргийн эмч	Мэдрэл судлал, Сэтгэц наркологи, Уламжлалт анагаах
7	Д.Чимгээ	Дотрын ерөнхий мэргэжилтэн	БОЭТ-ийн дотрын зөвлөх эмч	АУ-ны магистр, Тэргүүлэх зэргийн эмч	Дотрын өвчин судлал, Булчирхай, дотоод шүүрлийн эмгэг судлал, Хавдар судлал
8	Т.Давааноров	Халдварт өвчин судлалын ерөнхий мэргэжилтэн	БОЭТ-ийн халдвартын тасгийн эрхлэгч, зөвлөх эмч	АУ-ны магистр	Халдварт өвчин судлал, Бэлгийн замаар дамжих халдвар, Сүрьеэ судлал
9	Б.Бямбажав	Тархвар судлалын ерөнхий мэргэжилтэн	Эрүүл мэндийн газрын НЭМТ-ийн халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн	Магистрантур	Тархвар судлал, ЭШХ судлал
10	Д.Алтанчимэг	Зоонозын өвчин судлалын ерөнхий мэргэжилтэн	Зоонозын өвчин судлалын төвийн захирал		Мал, амьтнаас хүнд халдварлах өвчин судлал
11	Л.Лхагвасүрэн	Анхан шатны тусламжийн ерөнхий мэргэжилтэн	Шим билэг өрхийн эмнэлгийн ахлагч, аймгийн өрхийн эмнэлгүүдийн холбооны тэргүүн		Анхан шатны тусламж, үйлчилгээ, Сум, Өрхийн эрүүл мэндийн төвийн стратегийн хэрэгжилт
12	Д.Дүүмаам	Сувилахуйн ерөнхий мэргэжилтэн	Эрүүл мэндийн газрын ЭТҮХ-ийн чанар аюулгүй байдал, сувилахуйн тусламж хариуцсан мэргэжилтэн	Магистр	Сувилахуйн тусламж, үйлчилгээ
13	С.Шүрцэцэг	Эмгэг судлалын ерөнхий мэргэжилтэн	Шүүх шинжилгээний албаны шинжээч эмч	Ахлах зэргийн эмч	Эмгэг судлал, Шүүх шинжилгээ, Цитологи, Гистологи судлал

Эрүүл мэндийн газрын даргын  
2020 оны 04 дүгээр сарын 23-ний өдрийн  
А/38 дугаар тушаалын 2 дугаар хавсралт




**АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ЕРӨНХИЙ МЭРГЭЖИЛТНИЙ  
ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Эрүүл мэндийн газрын ерөнхий мэргэжилтний орон тооны бус зөвлөл /цаашид ерөнхий мэргэжилтний зөвлөл гэх/ нь аймаг орон нутгийн хэмжээнд эрүүл мэндийн салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, тухайн мэргэжлийн чиглэлээр бодлого боловсруулах, цаг үеийн тулгамдсан асуудлаар холбогдох газар, хэлтэстэй зөвшилцөн, санал, дүгнэлт, зөвлөмж гаргах, хамтарч ажиллах үндсэн чиг үүрэгтэй.
- 1.2. Ерөнхий мэргэжилтний зөвлөлийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар томилж, чөлөөлөх ба томилохдоо дараах шалгуурыг баримтална.
  - 1.2.1 Тухайн мэргэжлийн чиглэлээр нэр хүндтэй, салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн
  - 1.2.2 Мэргэжлээрээ 8 буюу түүнээс дээш жил ажилласан
  - 1.2.3 Мэргэжлийн зэрэг цолтой
  - 1.2.4 Ёс зүйн зөрчилд холбогдож байгаагүй
  - 1.2.5 Ашиг сонирхлын зөрчилгүй
  - 1.2.6 Багаар ажиллах чадвартай
  - 1.2.7 Дахин томилох тохиолдолд үүрэгт хугацаандаа идэвх санаачилгатай ажиллаж, байсан тодорхойлолт зэрэг болно.
- 1.3. Ерөнхий мэргэжилтэн нь тухайн жилд хийх ажлын төлөвлөгөөг мэргэжлийн чиглэл бүрээр гаргаж, ЭМГ-ын Эмнэлгийн тусламжийн хэлтсээр хянуулж, жил бүрийн 1 дүгээр сард багтаан ЭМГ-ын даргаар батлуулж хэрэгжүүлнэ.
- 1.4. ЭМГ-ын удирдлагын зөвлөл нь ерөнхий мэргэжилтний үйл ажиллагааны явц, цар хүрээ, гүйцэтгэлийн үнэлгээний дүн, хийсэн ажлын тайлан, үр дүнг харгалзан урамшуулал, цалингийн нэмэгдэл олгох, асуудлыг холбогдох байгууллагуудад албан бичгээр хагас, бүтэн жилээр уламжилна.
- 1.5. Ерөнхий мэргэжилтний зөвлөлийн дарга, гишүүдийг дараах тохиолдолд чөлөөлнө.
  - 1.5.1 Өөрөө хүсэлтээ гаргасан
  - 1.5.2 Эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар нэг жилээс дээш хугацаагаар үүрэгт ажлаа гүйцэтгээгүй бол
  - 1.5.3 Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргасан нь нотлогдсон
- 1.6 Ерөнхий мэргэжилтний зөвлөл нь сард 1-ээс доошгүй удаа /Эрүүл мэндийн газар дээр, сар бүрийн сүүлийн долоо хоногийн БААСАН гаригт/ хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд зөвлөлийн даргын шийдвэрээр хуралдаж болно. Гишүүдийн олонх буюу 70 хувийн ирцтэй тохиолдолд зөвлөлийн хурлыг хүчинтэйд тооцно.

**Хоёр. Ерөнхий мэргэжилтний ажлын чиг үүрэг**

- 2.1 Ерөнхий мэргэжилтэн нь тухайн мэргэжлийн чиглэлээр хурал, зөвлөгөөнд эрүүл мэндийн газрыг төлөөлөх эрхтэй оролцоно.
- 2.2 Тухайн чиглэлээр салбарын хөгжлийн чиг хандлага, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, хууль эрх зүйг хэрэгжүүлэхэд манлайлан оролцох, санал оруулах;



- 2.2 Тухайн чиглэлээр салбарын хөгжлийн чиг хандлага, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, хууль эрх зүйг хэрэгжүүлэхэд манлайлан оролцох, санал оруулах;
- 2.3 Тухайн мэргэжлийн чиглэлийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар санал оруулах, зөвлөмж өгөх дүгнэлт гаргах;
- 2.4 Эрүүл мэндийн газрын саналын дагуу холбогдох үйл ажиллагааг захиалгаар гүйцэтгэнэ.
- 2.5 Мэргэжлийн чиглэлээр шинээр гарч буй, оношилгоо, эмчилгээ, сувилахуйн стандарт, эмнэл зүйн удирдамжийг хэрэгжүүлэх, гарын авлагыг боловсруулах, сургалт зохион байгуулах;
- 2.6 Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг сайжруулах, тухайн мэргэжлийн онцлогийг тусгасан ёс зүйн өвөрмөц хэм хэмжээ болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх талаар санаачилгатай ажиллана.
- 2.7 Орон нутгийн хэмжээнд тухайн мэргэжлийн эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн өмнөх болон дараах сургалт, мэргэжлийн боловсон хүчний хангалт залгамж халааг бэлтгэхэд дадлагажуулах ажлыг санаачлан зохион байгуулах;
- 2.8 Нийгмийн эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, мэргэжлийн чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд идэвхтэй гарган, манлайлан оролцоно.
- 2.9 Тухайн мэргэжлийн чиглэлээр Эрүүл мэндийн газарт иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд оролцох, санал өгөх, газар дээр нь очиж хянаж үнэлэх, дүгнэлт гаргахад оролцоно.
- 2.10 Эрүүл мэндийн газрын хэлтсийн мэргэжилтнүүдтэй тухайн мэргэжлийн чиглэлээр хамтран ажиллах чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулна.
- 2.11 Ерөнхий мэргэжилтэн нь өөрийн мэргэжлийн цар хүрээ, чадварыг байнга дээшлүүлж, мэргэжлийн зэрэг дэвээ анхиулахад анхаарч, ёс зүйн хэмжээг чанд сахиж алдаа зөрчилгүй ажиллана.
- 2.12 Нутаг дэвсгэрийн хэмжээнд тухайн мэргэжлийн чиглэлээр зонхилон тохиолдож байгаа эмгэг, өвчлөлийн байдалд судалгаа хийх, орон нутгийн онцлогт тохирсон эмчилгээ, оношилгооны шинэ технологи нэвтрүүлэх, үр дүнг тооцоход манлайлан оролцож, суурь судалгаа нотолгоотой ажиллах;
- 2.13 Тухайн жилд хийсэн ажлын тайлангаа жил бүрийн 6, 12 дугаар сарын 25-ны өглөө багтаан ЭТҮХ /Ерөнхий мэргэжилтний зөвлөлийн дарга/-т бичгээр өгч, эрүүл мэндийн газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ажлаа дүгнүүлнэ.